

НЭГЭН ЧУЛУУН ХЭВИЙН ТУХАЙ

А.ОЧИР¹, Ж.БАЯРСАЙХАН², Ч.ЭНХТӨР³

¹Нүүдлийн соёл иргэнийг судлах олон улсын хүрээлэн

²Монголын Үндэсний Түүхийн Музей

e-mail: ja_bayaraa@yahoo.com

³Ховд аймгийн Манхан сумын 10 жилийн сургуулийн багш

Түлхүүр үгс: Хүрэл зэвсгийн үе, хүрэл цутгуур, чулуун хэв

Өгүүллийн товч агуулга: Энэ өгүүлэлд Монгол Алтайн бүс нутгаас олдсон нэгэн чулуун хэвийн хэлбэр, онцлог, он цагийг авч үзсэн болно. Уг чулуун хэв хоёр хэсгээс бүрдэх бөгөөд хэвэнд битүү болон задгай хоёр аргаар цутгуур хийж, эд зүйлсийг үйлдвэрлэх зориулалттай. Бид хэв дээр сийлсэн хутга, шөвөг, эд зүйлсийн хэлбэрт тулгуурлан уг хэвийг НТӨ 1300-700 оны орчим үйлдэн хэрэглэж байсан хэмээн үзэж байна.

I. ӨМНӨТГӨЛ:

Эл өгүүлэлд, Монгол орны хүрэл зэвсгийн түүхэнд холбогдох нэгэн сонирхолтой олдворын тухай танилцуулах болно. Монголын Үндэсний Түүхийн Музей, АНУ-ын Пенсильваний их сургуулийн хамтарсан “Ховд” төслийн баг 2007 оны 7, 8-р сард Ховд аймгийн Манхан сумын нутаг Тахилтын завсар¹ нэрт газар Хүннүгийн булш малтан судлах ажил зохион байгуулсан юм. Судалгааны явцад түүх соёлоо сонирхон дээдэлдэг орон нутгийн хүмүүстэй танилцсаны нэг нь тус сумын 10 жилийн дунд сургуулийн түүх, нийгмийн багш Ч. Энхтөр байсан юм. Тэрээр сум орон нутгийнхаа түүхийг сонирхон судлаж, шавь нартаа түүх соёлоо хүндлэн дээдлэх, утга учрыг таниулахыг хичээж яваа нэгэн байв. Тэр сургуулийнхаа түүхийн танхимыг тохижуулахаар орон нутгаасаа бага хэмжээний цуглуулга хийжээ. Түүний цуглуулга дотор бидний энд өгүүлэх цутгуурын чулуун хэв байв. Энэхүү цутгуурын чулуун хэв нь монгол төдийгүй хөрш зэргэлдээ орнуудын нутгаас цөөн тоогоор олдсон ховор дурсгал байсан юм. Тиймээс МҮТМ-н захирал профессор А.Очир тус олдворыг хөдөө орон нутагт байснаас нийслэл хотноо музейн үзмэр болгон олон нийтэд дэлгэн үзүүлэх нь чухал гэдэг саналыг Ч. Энхтөрд тавьсны үр дүнд тус олдворыг МҮТМ-н сан хөмрөгт шилжүүлэн авчирсан юм (МҮТМузейн бүртгэлийн дугаар: Ү-2007-2-99).

II. ЧУЛУУН ХЭВИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү цутгуурын чулуун хэвийг Ховд аймгийн Манхан, Зэрэг сумдын нутгийн заагт орших “Тооройн элс” хэмээх газраас Манхан сумын 10 жилийн сургуулийн нэгэн сурагч олжээ. Уг цутгуурын чулуун хэвийг цагаан саарал өнгийн баргилт чулуугаар хийсэн бөгөөд хоёр хэсгээс бүрдэж байна

¹ Өүәәүәүі ааднәі нбәәәәәәүі аіеіі абнәә чіөіөооәәә үіү аацдүә “Оәөөөдүі өідәәід” өүіүүі ае-еә өднүі аіе аеәіеә еәәәәнәәд іодәәеі өүіүүі аацдүә “Оәөөөдүі сәәнәд” аүә үүдөүәүә.

Чулуун хэвийн 1-р хэсэг: Хэмжээ: 22,2 см урт, 6,7 см өргөн, 2 см зузаан. Энэ хэсгийн нэг өргөн тал буюу задгай талд бөгтөр мөртэй, цагирган толттой хоёр хутга, тэдгээрийн хажууд бөөрөөрөө холбогдсон олон дугуй цагираг бүхий нэг хүрэл эдлэлийн хэвийг ухаж гаргажээ. Энэ тал дээр буй хоёр хутганы том нь балтагтай, жижиг нь балтаггүй байна (**Зураг 1А**). Харин нөгөө хэвтэй нийлэх талын голд богино иштэй, дундаа ховилтой, зууван дугуй тээглүүр бүхий урт шөвгийн хэв ухаж сийлээд, бусад талбайг тэгшлэн засжээ. Чулуун хэвийн энэ хэсгийн нэг булан нь хугарч унасан байсныг бид эвээр нь буцааж наасан болно (**Зураг 1Б**).

Чулуун хэвийн 2-р хэсэг: Хэмжээ: 22,3 см урт, 6,6 см өргөн, 2,6 см зузаан. Чулуун хэвийн энэ хэсгийн нэг өргөн тал буюу 1-р хэсэгтэй нийлэх тал дээр 1-р хэсэг дээр сийлэгдсэн урт шөвөгний нөгөө талыг ухаж гаргаад, түүний зүүн хажууд цагирган толт бүхий балтаггүй бөгтөр мөртэй хутга, хутганы хажууд хөндлөн огтлолоороо дөрвөлжин хэлбэртэй богинохон шөвөгний хэв үйлджээ. Харин урт шөвөгний баруун хажууд хоорондоо харилцан адилгүй зайтай таван хавтгай дугуйг хооронд нь холбосон өвөрмөц хүрэл эдлэлийг цутгах зориулалттай хэв хийсэн байна. Энэхүү таван хавтгай дугуйн эхний гурав нь бөөрөөрөө нийлж залгагдсан бол, дөрөв, тав дахь дугуй хоорондын зайг холдуулан дунд нь нарийн дугуй холбоосоор холбон цутгахаар хийжээ. Түүнчлэн гурваас дөрөв дэх хоёр хонхрын хоорондох нарийн холбоосны дунд хэсэгт хоёр тийшээ чагт (хэрээс) маягийн нарийн ховил гаргасан байна (**Зураг 2Б**). Хэвийн нөгөө өргөн тал буюу задгай талд цагирган тольттой, бөгтөр мөртэй, ир болон бариулыг заагласан жижиг балтаг бүхий нэг хутганы хэв сийлжээ (**Зураг 2А**).


III. ЦУТГУУРЫН ЯВЦ БОЛОН ЧУЛУУН ХЭВИЙН ОНЦЛОГ:

Энэхүү чулуун хэвийн хоёр хэсгийг хавсарч бөхлөөд гурван талд нь тусгайлан гаргасан нүхүүдээр цутгуурын хайлмаг гүйлгэх зориулалттай. Ингэж цутгахдаа хоёр хажууд гаргасан нарийн зураасуудыг харалдуулан нийлүүлж, цутгах эдлэлийг зөв хэлбэртэй гаргахаар хийжээ (**Зураг 3А-3Г**). Харин хоёр задгай талын хэвийг тэгш гадаргуутай зүйлээр дээрээс нь шахаж, доод талын сэтэрхий нүхүүдээр хайлмагаа хэв рүү нь цутгаж гүйлгэх аргаар эдлэлийг цутгаж байсан бололтой. Уг хэвний хавсарч нийлэх талууд дээр байгаа эдлэлүүдээс ганцхан урт шөвөг л бүтнээр цутгагдан гарахаар хонхойлгон сийлэгдсэн бөгөөд хутга болон бусад эдлэлүүдийн нэг тал нь бүгд хавтгай тэгш хэлбэртэйгээр буюу дан задгай цутгуурын эдлэл шиг хийгдэхээр төлөвлөгджээ. Монгол болон хөрш орнуудын нутгаас олдсон хүрэл эдлэлүүдийн дотор нэг тал нь тэгш хавтгай хүрэл эдлэл олон байдаг. Тухайлбал нэг талдаа ховил болон янз бүрийн хэлбэр дүртэй боловч нөгөө тал нь тэгш хавтгай гадаргуутай хүрэл хутганууд цөөнгүй олдсон байдаг нь чулуун хэвний дээрх хийцтэй холбоотой, цутгуурын хөгжлийн нэгэн шат байсан нь тодорхой байна.

IV. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

Төмөрлөг цутгуурын хамгийн эртний ул мөр болох зэсийн хайлш Мисирин нутгаас олдсон бөгөөд энэ нь ойролцоогоор НТӨ 4000 жилийн орчимд холбогдох аж. Харин Кавказ орчмын нутагт НТӨ III мянганы эхэн үед, Эртний Энэтхэгт НТӨ III мянганы дундуур, Хятадад НТӨ IV-III мянганы зааг үед (Vincent, 1999), бүр тодруулбал НТӨ 3100-2700 оны орчим (Li Liu, 2003) зэс болон хүрэл цутгуурын арга дэлгэрэн хөгжиж эхэлсэн байна. Эдгээр бүс нутагт хүрэл эд зүйлийг цутгахдаа, шавар хэв болон чулуун хэвийг өргөн ашиглаж байжээ (Vincent, 1999). Чулуун хэв нь дотроо цутгах аргаараа дан задгай болон хоорондоо нийлж бүтсэн битүү хэв гэсэн ерөнхий

хоёр хэлбэртэй байжээ. Хоорондоо нийлж бүтдэг хэв нь зөвхөн хоёроор хязгаарлагдахгүй олон хэсгээс бүрддэг байв (Vincent, 1999). Хятадад хүрэл цутгуурын хөгжлийн эхэн үед хэвний эх загварыг шавраар хийж, шатаах зууханд бэхжүүлээд, дараа нь төмөрлөгөө хайлуулан цутгадаг байсан бол яваандаа багаж зэвсэг зэрэг жижиг зүйлсийг хийхдээ чулуун хэвийг өргөн ашиглах болжээ (Ting Morris, 2006). Умард Хятадын хүрэл зэвсгийн үеийн Эрлитоу (НТӨ 1800-1600), Эртний Шан улсын үед холбогдох Эрлиган (НТӨ 1600-1400) зэрэг дурсгалт газруудаас олон төрлийн эд зүйл хийх шавар болон чулуун хэвнүүд олдсон (Li Liu, 2003) байна. Мөн Минус болон Арал тэнгисийн сав газар Андроновын үед шавар хэв ашиглаж байсан бол, Карасукийн үед хавсарч цутгадаг нийлмэл чулуун хэвийг өргөн хэрэглэх болсон (Sophie, 2006) тухай мэдээ бий.



Дээр дурдсан хоёр бүс нутгийн соёлын дунд орших эртний нүүдэлчдийн өлгий, өнөөгийн Монгол орны нутгаас хүрлээр хийсэн эд өлөг олон тоогоор олддог боловч тэдгээрийг үйлдвэрлэн гаргаж байсан хэв маш цөөн олдсон юм. 1970-аад

- Цыбиктаров.А.Д.*, 1998. Культура плиточных могил Монголии и Забайкалья. Улан-Удэ.
- Цэвээндорж Д.*, 1974. Чулуун хэв. Шинжлэх ухааны амьдрал. 11. УБ.
- Li Liu*, 2003. The Products of Minds as Well as Hands. Production of prestige goods in the Neolithic and Early state periods of China. Asian perspectives, Vol .42, No .1.
- Sophie Legrand*, 2006. The emergence of the Skythians: Bronze Age and Iron Age in South Siberia. Antiquity, 80: 843-879
- Ting Morris*, 2006. Arts and crafts of Ancient China
- Vincent C. Pigott*, 1999. The Archaeometallurgy of the Asian Old World.
- 내몽고 중남부의 오르도스 청동기와 문화*, (*Ordos bronze ware and the culture of south and central inner Mongolia*), 2006. Kogyryo Research Foundation.

РЕЗЮМЕ

А.Очир, Ж.Баярсайхан, Ч.Энхтор

НЕКОТОРЫЕ ЗАМЕТКИ О НАХОДКЕ ЛИТЕЙНОЙ ФОРМЫ ИЗ ХОВД АЙМАГ

В 2007 году в ходе археологических исследований и ознакомлений с достопримечательностями края в местности “Тоорой элс” между Манхан и Зэрэг сомонами Ховд аймага была найдена литейная форма из камня породы сланцевых. Форма состоит из двух составных створок и на каждой из четырех плоскостей выточены рельефом контуры изделий для отливки бронзовых изделий. Формовочка по аналогии изделий датируется бронзовым периодом или хронологически лежит между 1300-700 в.н.э.